



**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2016 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**Улаанбаатар хот
2016.08.22**

АГУУЛГА

Нэг. ББСБ-ын салбарын өнөөгийн байдал.....	1
Хоёр. Нэгтгэлийн статистик үзүүлэлт.....	5
2.1 Ерөнхий статистик үзүүлэлт	5
2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	6
2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	6
2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ	7
Гурав. Активын бүтэц, чанар, зээлийн үйл ажиллагаа.....	7
3.1 Активын бүтэц, өөрчлөлт	8
3.2 Зээлийн багцын чанар	9
3.3 Активын бусад үзүүлэлтийн талаар	10
Дөрөв. Пассивын бүтэц, өөрчлөлт	11
Тав. Орлого, зарлага, ашигт ажиллагаа.....	12
Зургаа. Салбарын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	15
Долоо. Хууль тогтоомжийн хэрэгжилт.....	17
Найм.Дүгнэлт.....	18

Хавсралт 1:ББСБ-уудын нэгдсэн тэнцэл

Хавсралт 2: Орлого, үр дүнгийн тайлан

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2016 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2016.8.22

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тайлант оны эхний хагас жилд Хорооны хуралдаанаар 53 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 4 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 499 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.


Хороо байгуулагдсанаас хойш буюу 2006 оны тайлант жилээс эхлэн ББСБ-уудын тооны өөрчлөлтийг харуулбал:

Хүснэгт 1

№	Тайлант хугацаа	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-
4	2009 он	177	27	9	47
5	2010 он	182	26	15	48
6	2011 он	195	23	17	39
7	2012 он	212	24	17	38
8	2013 он	263	31	19	41
9	2014 он	378	40	23	53
10	2015 он	450	50	27	52
11	2016 оны II улирал	499	53	30	51

ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

График 1



Дээрх тоон мэдээнээс харахад тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын тоо 2006 оны мөн үетэй харьцуулахад 3.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хорооноос ББСБ-уудын тусгай зөвшөөрлийн зохицуулалтын асуудлуудыг шийдвэрлэсэн байдал:

Хүснэгт 2

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011 он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 он	120	5	5	1	378
10	2015 он	80	8	6	5	450
11	2016 оны II улирал	53	4	-	1	499

2016 оны эхний хагас жилд Хорооны хуралдаанаар 53 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 4 банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох, 1 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан эрхлэх үйл ажиллагааны төрлөөр ББСБ-уудыг ангилвал:

Хүснэгт 3

д/д	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын давхардсан тоогоор		Өөрчлөлт	
		2015 оны II улирал	2016 оны II улирал	тоо	хувь
	Нийт ББСБ	423	499	76	18.0
1	Гадаад валютын арилжаа	131	142	11	8.4
	<i>Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг</i>	52	51	(1)	(1.9)
2	Зээл	361	443	83	23.0
3	Факторингийн үйлчилгээ	17	22	5	2.9
4	Төлбөрийн баталгаа гаргах	13	16	3	23.1
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	-	1	1	100.0
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	12	6	100.0
7	Итгэлцлийн үйлчилгээ	25	28	3	12.0
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	-	-
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	26	33	7	27.0

2016 оны хоёрдугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 499 ББСБ-ын 28.4 хувь буюу 142 ББСБ гадаад валютын арилжаа эрхэлж байгаагаас 10.2 хувь буюу 51 ББСБ нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байна.

Мөн нийт ББСБ-ын 88.8 хувь буюу 443 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 6.6 хувь буюу 33 ББСБ хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 3.2 хувь буюу 16 ББСБ төлбөрийн

баталгаа гаргах, 5.6 хувь буюу 28 ББСБ итгэлцлийн үйлчилгээ, 4.4 хувь буюу 22 ББСБ факторингийн үйлчилгээ, 2.4 хувь буюу 12 ББСБ цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.4 хувь буюу 2 ББСБ богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхэлж байна.

Зах зээлийн эрэлтийг дагаж энэхүү салбарт оролцогчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 76 компани буюу 18 хувиар, тэр дундаа зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 83 компаниар буюу 23.0 хувиар, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгчдийн тоо 1 дахин буюу 6 компаниар нэмэгдсэн нь хамгийн их хэрэгцээтэй үйлчилгээ болох нь харагдаж байна.

2016 оны хоёрдугаар улирлын тайлан мэдээг ирүүлбэл зохих нийт 499 ББСБ-аас 456 ББСБ буюу 91.4 хувь нь зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан болно.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харуулбал:


Хүснэгт 4

/мянган төгрөгөөр/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны II улирал	2016 оны II улирал	Өөрчлөлт /+/, -/	
				дүн	хувь
1	ББСБ-ын тоо	423	499	76	18.0
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	849	986	137	16.1
3	Ажиллагсадын тоо	1774	2048	274	15.4
4	Салбар нэгжийн тоо	99	124	25	25.2
5	Харилцагчдын тоо	457,540.0	420,505.0	(37,035.0)	(8.1)
6	Нийт актив	554,486,688.9	676,535,675.8	122,048,986.9	22.0
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		2.6	2.9	0.3	11.5
Нийт зээлийн өрийн үлдэгдэл		362,319,194.6	412,072,970.5	49,753,775.9	13.7
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		3.2	3.4	0.2	6.3
8	Нийт эздийн өмч	368,056,017.9	507,041,000.2	138,984,982.3	37.8
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		14.9	19.7	4.8	32.2
9	Нийт дүрмийн сан	285,029,965.8	388,843,755.4	103,813,789.6	36.4
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	32,494,933.5	26,747,511.1	(5,747,422.4)	(17.7)
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл	123,650,226.2	101,918,060.8	(21,732,165.4)	(17.6)
Үүнээс: Богино хугацаат зээл		65,797,192.9	53,408,080.8	(12,389,112.1)	(18.8)
Урт хугацаат зээл		57,853,033.3	48,509,980.0	(9,343,053.3)	(16.1)
12	Төслийн зээлийн санхүүжилт	14,251,061.0	20,057,341.6	5,806,280.6	40.7
13	Нийт орлого	77,173,104.8	84,195,759.0	7,022,654.2	9.1
14	Нийт зардал	56,220,178.2	59,155,454.1	2,935,275.9	5.2
15	Тайлант үеийн ашиг	20,952,926.6	25,040,304.9	4,087,378.3	19.5

Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй 499 ББСБ-уудын 53 ББСБ буюу 10.6 хувь нь хөдөө орон нутагт, 446 ББСБ буюу 89.4 хувь нь хүн амын төвлөрлөө дагаад УБ хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Харин Говь-Алтай, Увс аймгуудад ББСБ байгуулагдаагүй байна.

ББСБ-уудын байршлыг үзүүлбэл:



2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

Тайлант улиралд орон нутагт төвтэй ББСБ-уудын актив хөрөнгө нь салбарын нийт активын 2.4 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь 3.1 хувь, эздийн өмч нь 2.8 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2.1 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 5

/мянган төгрөгөөр/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны II улирал	2016 оны II улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	47	53	6
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>10.9</i>	<i>10.6</i>	<i>(0.3)</i>
А	Нийт актив	14,964,758.9	16,336,863.1	1,372,104.2
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>2.7</i>	<i>2.4</i>	<i>(0.3)</i>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	11,846,277.2	12,768,767.1	922,489.9
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>3.3</i>	<i>3.1</i>	<i>(0.2)</i>
	Чанаргүй зээл	224,003.6	535,550.1	311,546.5
	<i>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь</i>	<i>1.9</i>	<i>4.2</i>	<i>2.3</i>
В	Нийт эздийн өмч	11,436,831.0	14,336,203.9	2,899,372.9
	<i>ББСБ-ын нийт эздийн өмчид эзлэх хувь</i>	<i>3.1</i>	<i>2.8</i>	<i>(0.3)</i>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/	7,743,229.5	8,330,046.2	586,816.7
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>2.7</i>	<i>2.1</i>	<i>(0.6)</i>

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

Тайлант улиралд гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 30 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 6 хувь, тэдгээрийн актив нь салбарын нийт активын 16.3 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь салбарын 14.5 хувь, эздийн өмч нь салбарын 11.8 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын 13.1 хувийг тус тус эзэлж байна.

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны II улирал	2016 оны II улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	21	30	9
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>5.0</i>	<i>6.0</i>	<i>1.0</i>
А	Нийт актив	66,851,666.8	110,583,706.4	43,732,039.6
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>12.1</i>	<i>16.3</i>	<i>4.2</i>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	53,169,632.0	65,853,401.4	12,683,769.4
	Үүнээс: Чанаргүй зээл	4,056,212.2	9,575,360.7	5,519,148.5
	<i>Нийт гадаад хөрөнгө оруулалттай ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>14.7</i>	<i>14.5</i>	<i>(0.2)</i>
В	Нийт эздийн өмч	37,238,094.3	59,733,549.0	22,495,454.7
	<i>ББСБ-ын нийт эздийн өмчид эзлэх хувь</i>	<i>10.1</i>	<i>11.8</i>	<i>1.7</i>
Г	Нийт дүрмийн сан	26,781,897.4	50,992,766.6	24,210,869.2
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>9.3</i>	<i>13.1</i>	<i>3.8</i>

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 11, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, АНУ, Хятадын хөрөнгө оруулалттай тус бүр 2, Хонг Конгийн хөрөнгө оруулалттай 3, ОХУ, Сичель, Франц, Англи, Люксембург, Малайз, Швейцарийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:

Тайлант хугацааны эцэст Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 499 ББСБ-ын 40 хувь буюу 142 ББСБ гадаад валютын арилжаа эрхэлж байгаагаас 10.2 хувь буюу 51 компани нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байна. Тус ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харуулбал:

Хүснэгт 7

/мянган төгрөгөөр/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны II улирал	2016 оны II улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагааг эрхэлж буй ББСБ-ын тоо	52	51	(1)
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>12.3</i>	<i>10.2</i>	<i>2.1</i>
А	Нийт актив	9,505,049.5	10,163,961.7	658,912.2
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>1.7</i>	<i>1.5</i>	<i>(0.2)</i>
Б	Нийт эздийн өмч	9,449,104.5	10,098,407.7	649,303.2
	<i>ББСБ-ын нийт эздийн өмчид эзлэх хувь</i>	<i>2.6</i>	<i>2.0</i>	<i>(0.6)</i>
В	Нийт дүрмийн сан	7,708,550.0	9,524,076.4	1,815,526.4
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>2.7</i>	<i>2.4</i>	<i>(0.3)</i>

Гадаад валют арилжаа эрхэлж буй ББСБ-уудын нийт хөрөнгө 10,163,961.7 мянган төгрөг буюу салбарын нийт активын 1.5 хувь, эздийн өмч 10,163,961.7 мянган төгрөг буюу салбарын нийт эздийн өмчийн 2.0 хувь, хувьцаат капитал нь 9,524,076.4 мянган төгрөг буюу салбарын нийт хувьцаат капиталын 2.4 хувийг тус тус эзэлж байна. Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өссөн, эздийн өмч 0.6 хувиар, дүрмийн сангийн хэмжээ 0.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй гарсан байна.

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант хугацааны ББСБ-уудын активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

д/д	ХӨРӨНГӨ	2015 II улирал		2016 II улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
А	Эргэлтийн хөрөнгө	535,546,883.4	96.6	650,475,384.0	96.1	114,928,500.6	21.5
1	Мөнгөн хөрөнгө	144,957,319.6	26.1	207,821,699.3	30.7	62,864,379.7	43.4
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	11,069,167.3	2.0	1,273,240.8	0.2	(9,795,926.5)	(88.5)
3	Нийт зээл	362,319,194.6	65.3	412,072,970.5	60.9	49,753,775.9	13.7
	(Зээлийн эрсдлийн сан)	21,019,868.4	3.8	33,461,288.1	4.9	12,441,419.7	59.2
4	Нийт факторингийн тооцооны авлага	90,312.9	-	100,000.0	-	9,687.1	10.7
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	30,600.0	-	30,000.0	-	(600.0)	(2.0)
5	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	1,741,836.3	0.3	2,743,947.1	0.4	1,002,110.8	57.5
6	Бусад хөрөнгө	36,412,113.4	6.6	59,954,814.4	8.9	23,542,701.0	64.7
Б	Эргэлтийн бус хөрөнгө /цэврээр/	18,939,805.5	3.4	26,060,291.8	3.9	7,120,486.3	37.6
7	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	24,247,485.4	4.4	32,703,212.4	4.8	8,455,727.0	34.9
	(Хуримтлагдсан элэгдэл)	5,307,679.9	1.0	6,642,920.5	1.0	1,335,240.6	25.2
НИЙТ ХӨРӨНГӨ		554,486,688.9	100.0	676,535,675.8	100.0	122,048,986.9	22.0

Өмнөх оны мөн үеийн байдлаар 423 ББСБ-уудын нийт хөрөнгө 554.5 тэрбум төгрөг, активын өсөлт 25 хувь байсан бол тайлант хугацаанд 499 ББСБ-уудын нийт хөрөнгө 676.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 122.0 тэрбум төгрөгөөр буюу 22 хувиар өссөн үзүүлэлтэй байна.


Активын өсөлтийг өмнөх онуудтай харьцуулбал:

График 3



Тайлант хугацааны нийт активын 96.2 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.8 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байгаа ба өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

График 4



Эргэлтийн хөрөнгийн 30.7 хувийг мөнгөн хөрөнгө, 60.9 хувийг олгосон зээлийн өрийн үлдэгдэл тус тус эзэлж байгаа бол нийт мөнгөн хөрөнгийн 46.9 хувийг бэлэн мөнгө, 53.1 хувийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж эзэлж байна.

3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 9

/мянган төгрөгөөр/

д/д	Ангилал	2015 II улирал		2016 II улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Хэвийн	309,610,667.6	85.5	330,895,909.5	80.3	21,285,241.9	6.9
2	Хугацаа хэтэрсэн	24,300,242.5	6.7	32,054,265.2	7.8	7,754,022.7	31.9
3	Чанаргүй зээл: Үүнээс	28,408,284.5	7.8	49,122,795.8	11.9	20,714,511.3	72.9
	Хэвийн бус	8,210,714.6	2.3	14,076,746.8	3.4	5,866,032.2	71.4
	Эргэлзээтэй	8,822,012.8	2.4	12,240,120.5	3.0	3,418,107.7	38.7
	Муу	11,375,557.1	3.1	22,805,928.5	5.5	11,430,371.4	100.5
4	(Зээлийн эрсдэлийн сан)	21,019,868.4	5.8	33,461,288.1	8.1	12,441,419.7	59.2
Нийт зээл		362,319,194.6	100.0	412,072,970.5	100.0	49,753,775.9	13.7
1	Үүнээс: Төгрөгөөр олгосон зээл	320,047,062.6	88.3	373,875,433.6	90.7	53,828,371.9	16.8
2	Гадаад валютаар олгосон зээл	42,272,132.0	11.7	38,197,536.9	9.3	(4,074,595.1)	(9.6)


Тайлант хугацаанд нийт зээлийн багц өмнөх оны мөн үеэс 49.7 тэрбум төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна.


Нийт зээлд эзлэх гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.1 тэрбум төгрөгөөр буюу 9.6 хувиар буурч, төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 53.8 тэрбум төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн байгаа нь төгрөгийн зээлийн эрэлт их байгаа нь харагдаж байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангилалын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 20.7 тэрбум төгрөгөөр буюу 72.9 хувиар өссөн нь зээлийн багцын чанар түүний дотор муу зээлийн хэмжээ 1 дахин нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд үүнтэй уялдуулан зээлийн эрсдлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 12.4 тэрбум төгрөгөөр буюу 59.2 хувиар өссөн байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

График 5





Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 443 ББСБ-уудын 412.1 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдлийн 11.9 хувь буюу 49.1 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байна.

3.4 Активын бусад үзүүлэлтийн талаар:

Богино хугацаат хөрөнгө оруулалтын /цэврээр/ данс 1,273.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

Хүснэгт 10

/мянган төгрөгөөр/

д/д	Богино хугацаат хөрөнгө оруулалтын төрөл	Хэмжээ	Эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	87,109.9	6.9
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	1,186,130.9	93.1
3	Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл, ямдруулалт	-	-
НИЙТ		1,273,240.8	100.0

Факторингийн тооцооны авлагын 70.0 хувь нь буюу 70,000.0 мянган төгрөг нь хэвийн, 30.0 хувь нь буюу 30,000.0 мянган төгрөг нь муу авлагад ангилагдан 30,000.0 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 499 ББСБ-ын 32.7 тэрбум төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгөд 6,642,920.5 мянган төгрөгийн элэгдэл тооцсон байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 11

/мянган төгрөгөөр/

д/д	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2015 II улирал		2016.6.30 II улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
А	Нийт өр төлбөр	186,430,671.1	33.6	169,494,675.6	25.1	(16,935,995.5)	(9.1)
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	32,494,933.5	5.9	26,747,511.1	4.0	(5,747,422.4)	(17.7)
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	123,650,226.2	22.3	101,918,060.8	15.1	(21,732,165.4)	(17.6)
3	Бусад эх үүсвэр	2,132,947.1	0.4	3,035,058.9	0.4	902,111.8	42.3
	Зээлийн батлан даалтанд	42,586.2	-	-	-	(42,586.2)	(100.0)

байриуулсан эх үүсвэр							
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,090,360.9	0.4	386,588.2	0.1	(1,703,772.7)	(81.5)
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	-	-	2,648,470.7	0.4	2,648,470.7	100.0
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	1,688,611.5	0.3	1,506,548.3	0.2	(182,063.2)	(10.8)
5	Төслийн зээлийн санхүүжилт	14,251,061.0	2.6	20,057,341.6	3.0	5,806,280.6	40.7
6	Бусад өр төлбөр	12,212,891.8	2.2	16,230,154.8	2.4	4,017,263.0	32.9
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3,892,048.2	0.7	5,176,656.8	0.8	1,284,608.6	33.0
	Бусад пассив	8,320,843.6	1.5	11,053,498.1	1.6	2,732,654.5	32.8
Б	Эздийн өмч	368,056,017.9	66.4	507,041,000.2	74.9	138,984,982.3	37.8
9	Хувьцаат капитал	285,029,965.7	51.4	388,843,755.4	57.5	103,813,789.7	36.4
10	Бусад өмч	8,550,484.5	1.5	8,691,227.4	1.3	140,742.9	1.6
11	Сангууд	340,188.0	0.1	488,155.8	0.1	147,967.8	43.5
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	72,435,464.1	13.1	108,214,105.9	16.0	35,778,641.8	49.4
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	1,699,915.5	0.3	803,755.8	0.1	(896,159.7)	(52.7)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		554,486,688.9	100.0	676,535,675.8	100.0	122,048,986.9	22.0


2015 оны хоёрдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 423 ББСБ -ийн хөрөнгийн эх үүсвэр 554.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоо мөн үеэс 110.9 тэрбум төгрөгөөр буюу 25.0 хувиар өсч байсан бол тайлант хугацаанд 499 ББСБ-уудын хөрөнгийн эх үүсвэр 676.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 122.0 тэрбум төгрөгөөр буюу 22 хувиар өссөн байна.


Тайлант улиралд ББСБ-уудын нийт хөрөнгийн 25.1 хувийг өр төлбөр, 74.9 хувийг эздийн өмч эзэлж байна. Нийт өр төлбөр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.9 тэрбум төгрөгөөр буюу 9.1 хувиар буурч, өөрийн хөрөнгө 138.9 тэрбум төгрөгөөр буюу 37.8 хувиар өссөн байна.

ББСБ-ууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээр нь өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг сайжруулж, мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой билээ. Түүнчлэн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо хийгээд ББСБ-уудын хуримтлагдсан ашиг жилээс жилд хурдацтай өсч байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын хэмжээг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 6





2016 оны хагас жилийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 28 ББСБ байгаагаас нэр бүхий 22 ББСБ 26,747,511.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн нь салбарын өр нийт төлбөрийн 15.8 хувьтай тэнцэж байна.

2016 оны хоёрдугаар улирлын байдлаар цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 12 ББСБ байгаагаас нэр бүхий 3 ББСБ өрийн үлдэгдэл 3,035,058.9 мянган төгрөг байна. Энэ нь салбарын нийт өрийн 1.8 хувь, актив нь 40,076,422.5 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 5.9 хувь, эздийн өмчийн дүн 29,329,004.9 мянган төгрөг байгаа нь салбарын мөн үзүүлэлтийн 5.8 хувьтай тэнцэж байна.

Тайлант хугацаанд 4 ББСБ нийт 1,506,548.3 мянган төгрөгийн хаалттай өрийн бичиг бүртгэлтэй байна. Үүнд:

2016 оны хоёрдугаар улирлын байдлаар 6 ББСБ нийт 803,755.8 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэгдсэн байна. Үүнд:

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант улиралд ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

Хүснэгт 12

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2015 II улирал		2016 II улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Хүүгийн орлого	55,434,918.0	71.8	65,507,259.0	77.8	10,072,341.0	18.2
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	53,390,344.7	96.3	62,374,501.0	74.1	8,984,156.3	16.8
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	1,403,219.6	2.5	2,159,072.6	2.6	755,853.0	53.9
	Үнэт цаасны хүүгийн орлого	71,651.8	0.1	17,279.0	0.0	(54,372.8)	(75.9)
	Бусад хүүгийн орлого	569,701.9	1.0	956,406.5	1.1	386,704.6	67.9
2	Хүүгийн бус орлого	20,897,632.9	27.1	17,204,231.5	20.4	(3,693,401.40)	(17.7)
3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	766,790.0	1.0	1,484,268.5	1.8	717,478.5	93.6
4	Ердийн бус орлого	73,763.9	0.1	-	-	(73,763.9)	(100.0)

	Нийт орлого	77,173,104.8	100.0	84,195,759.0	100.0	7,022,654.2	9.1
--	-------------	--------------	-------	--------------	-------	-------------	-----

ББСБ-уудын үндсэн үйл ажиллагааны буюу хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар өсөж, нийт орлогын 77.8 хувийг эзэлж байна. Харин хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар буурч, нийт орлогын 20.4 хувийг эзэлж байгаа ба нийт орлогын дүнд эзлэх үндсэн бус үйл ажиллагааны орлого өмнөх оны мөн үеэс 93.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүүгийн бус орлого дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 13

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2015 II улирал		2016 II улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Арилжааны орлого	1,878,717.5	9.0	1,421,868.8	8.3	(456,848.7)	(24.3)
1.1	Гадаад валютын арилжааны орлого	1,878,690.3	9.0	1,421,868.8	8.3	(456,821.5)	(24.3)
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	27.2	-	-	-	(27.2)	(100.0)
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	15,693,083.2	75.1	11,190,305.5	65.0	(4,502,777.7)	(28.7)
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	14,865,453.6	71.1	11,190,305.5	65.0	(3,675,148.1)	(24.7)
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	827,629.6	4.0	-	-	(827,629.6)	(100.0)
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	3,325,832.2	15.9	4,591,143.1	26.7	1,265,310.9	38.0
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	4,100.9	-	-	-	(4,100.9)	(100.0)
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	3,066.2	-	184.9	-	(2,881.3)	(94.0)
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	306,823.0	1.5	288,231.0	1.7	(18,592.0)	(6.1)
3.4	Картын үйлчилгээний орлого	60.0	-	430.0	-	370.0	616.7
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	368,238.5	1.8	1,340,466.5	7.8	972,228.0	264.0
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,173,353.1	10.4	2,101,384.2	12.2	(71,968.9)	(3.3)
3.7	Бусад	470,190.5	2.2	861,360.5	5.0	391,170.0	83.2
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	20,897,632.9	100.0	17,204,231.5	100	(3,693,401.4)	(17.7)

2015 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 75.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 15.9 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол тайлант улиралд нийт хүүгийн бус орлогын 8.3 хувийг гадаад валютын арилжааны орлого, 65.0 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 26.7 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого тус тус эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

Хүснэгт 14

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2015 II улирал		2016 II улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Хүүгийн зардал	6,959,551.1	12.4	7,645,913.3	12.9	686,362.2	9.9
2	Хүүгийн бус зардал	38,452,974.4	68.4	37,811,173.2	63.9	(641,801.2)	(1.7)
3	Болзошгүй эрсдэлийн зардал	7,613,021.3	13.5	9,903,757.9	16.7	2,290,736.6	30.1
4	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	484,131.7	0.9	594,957.0	1.0	110,825.3	22.9
5	Ердийн бус зардал	7,812.8	-	-	-	(7,812.8)	(100.0)

Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагын газар

6	Орлогын татварын зардал	2,702,686.9	4.8	3,199,652.7	5.4	496,965.8	18.4
	НИЙТ ЗАРДАЛ	56,220,178.2	100.0	59,155,454.1	100.0	2,935,275.9	5.2

Тайлант хугацаанд нийт зардал өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар, үүний дотор хүүгийн зардал 9.9 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 30.1 хувиар, орлогын татварын зардал 18.4 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 22.9 хувиар тус тус өсөж, хүүгийн бус зардал 1.7 хувиар буурсан бөгөөд тайлант хугацаанд нийт 25,040,304.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 15


/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2015.6.30	2016.6.30	Өөрчлөлт	
		Дүн	Дүн	Дүн	Хувь
1	Нийт орлого	77,173,104.8	84,195,759.0	7,022,654.2	9.1
2	Нийт зардал	56,220,178.2	59,155,454.1	2,935,275.9	5.2
	Татварын дараах цэвэр ашиг	20,952,926.6	25,040,304.9	4,087,378.3	19.5

Тайлант хугацаанд нийт 25,040,304.9 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.5 хувиар өссөн байна.

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулбал:

График 8



Тайлант улиралд 406 ББСБ буюу нийт ББСБ-ын 80 хувь нь 21,521,070.8 мянган төгрөгийн ашигтай, 93 ББСБ буюу нийт ББСБ-уудын 19 хувь нь 3,519,234.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тэнцлийн гадуурх дансны нийт үлдэгдэл 448,660,682.2 мянган төгрөг байгаагаас үнэ бүхий зүйл 410,479,457.8 мянган төгрөг зээл болон бусад хөрөнгийн тооцооны үлдэгдэл 3,518,847.4 мянган төгрөг байна.

ЗУРГАА. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ-ын санхүүгийн тайлангийн Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон шалгуур үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

1/ Валют арилжааны ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт:

Хүснэгт 16

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	45	88.2

2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	5.9
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	5.9
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
	НИЙТ	51	100.0

Валют арилжааны ББСБ-ын тооцвол зохих 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

-нийт өөрийн хөрөнгө 12,302,816.1 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 8,307,482.0 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 94.4 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлага 92.6 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;

-төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;

-нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 300,037.1 мянган төгрөг, нийт актив 15,576,588.4 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 96.3 хувиар;

-өрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тус тус бүрэн хангасан;

Зээл санхүүжилтын ББСБ зохистой харьцааны шалгуур үзүүлэлт:

Хүснэгт 17

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	271	68.4
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	80	20.2
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	34	8.6
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	7	1.8
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	0.8
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	0.3
	НИЙТ	396	100.0

Зээл санхүүжилтын ББСБ-ын тооцвол зохих 14 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

-нийт өөрийн хөрөнгө 340,331,782.4 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 647,107,655.5 мянган төгрөг байгаа нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 94.7 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 94.4 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 99.0 хувиар;

-нийт түргэн борлогдох актив 119,840,421.9 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 52,945,082.8 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага 97 хувиар;

-нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 87.8 хувиар;

-нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 13,982,099.4 мянган төгрөг, нийт актив 393,276,865.1 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 94.2 хувиар;

- активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг 99.5 хувиар тус тус хангасан байна.

Хөрөнгө удирдлагын ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт:

Хүснэгт 18

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	34	70.8
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	9	18.8
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	4.2
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	4.2
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	2.1
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
	НИЙТ	48	100.0

Хөрөнгө удирдлагын ББСБ-ын тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

-нийт өөрийн хөрөнгө 154,406,401.8 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 213,371,574.4 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага бүрэн хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага 97.9 хувиар;

-нийт түргэн борлогдох актив 74,283,522.2 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 109,529,822.3 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага 91.7 хувиар;

-нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 91.6 хувиар;

-итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 26,747,511.1 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 154,406,401.8 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 80 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;

-нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 11,778,155.3 мянган төгрөг, нийт актив 267,682,222.3 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 91.6 хувиар;

-гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 1,429,548.3 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 154,406,401.8 мянган төгрөг байгаагаас хаалттай өрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 50 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;

-активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг тус тус бүрэн хангаж ажилласан байна.

ДОЛОО. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 443 ББСБ-ын 69.3 хувь буюу 307 ББСБ энэ үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

2. Энэ онд нийт 443 ББСБ-аас 398,525.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 371 ББСБ 310,447.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төвлөрүүлсэн. Биелэлт 79.7 хувьтай байна.

3. Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үүргийг оны эхний хагас жилд үйл ажиллагаа эрхэлж байсан 499 ББСБ-ын 42.9 хувь буюу 214 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ

1. 2016 оны хоёрдугаар улирлын тайлан мэдээг ирүүлбэл зохих нийт 499 ББСБ-аас 456 ББСБ буюу 91.4 хувь нь зохих ёсоор бүрэн, нэр бүхий 28 ББСБ эхлэлийн тайлан тэнцлээр, 15 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан байна.

2. Тайлант хугацаанд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 76 компаниар буюу 18.0 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 137-ээр буюу 16.1 хувиар нэмэгдсэн байна. Салбарт ажиллагсдын тоо 274 хүнээр нэмэгдэж 2048-д хүрсэн нь байна.

3. Улсын хэмжээнд 499 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 89.4 хувь буюу 446 нь УБ хотод, 10.6 хувь буюу 53 нь Говь-Алтай, Увс аймгуудаас бусад орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

4. Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 676.5 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 2.9 хувьтай, зээлийн өрийн үлдэгдэл 412.1 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.4 хувьтай, эзэмшигчдийн өмч 507.0 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 19.7 хувьтай тус тус тэнцэж байна.

5. ББСБ-уудын зарим үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 122.0 тэрбум төгрөгөөр буюу 22 хувиар, нийт активт эзлэх зээлийн хэмжээ 13.7 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 49.7 тэрбум төгрөгөөр, эздийн өмч 139.0 тэрбум төгрөгөөр буюу 37.8 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 103.8 мянган төгрөгөөр буюу 36.4 хувиар тус тус өссөн байна.

6. ББСБ-уудын өр төлбөрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өр 5.7 тэрбум төгрөгөөр буюу 17.7 хувиар, банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн өр 21.7 тэрбум төгрөгөөр буюу 17.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

7. Тайлант үеийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, нийт зээлийн хэмжээ 49.7 тэрбум төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна.

Нийт 412.1 тэрбум төгрөгийн зээлийн багцын 90.7 хувь нь төгрөгийн, 9.3 хувь нь гадаад валютын зээл эзэлж байна. Нийт зээлийн багцад эзлэх төгрөгөөр олгосон зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 53.8 тэрбум төгрөгөөр буюу 16.8 хувиар өсч, гадаад валютаар олгосон зээл 4.0 тэрбум төгрөгөөр буюу 9.6 хувиар буурсан байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангилалын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдсэн, нийт чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 20.7 тэрбум төгрөгөөр буюу 72.9 хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ, түүний дотор муу зээлийн хэмжээ 1 дахин нэмэгдсэнтэй холбогдон зээлийн эрсдэлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 12.4 тэрбум төгрөгөөр буюу 59.2 хувиар өссөн байна.

8. ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 25,040,304.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.1 тэрбум төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн байна. Нийт ББСБ-ын 73.1 хувь буюу 365 ББСБ 28,559,539.1 мянган төгрөгийн ашигтай, 18.6 хувь буюу 93 ББСБ 3,519,234.2 мянган төгрөгийн алдагдалтай, 8.2 хувь буюу 41 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР